



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2013 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 91

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Хороодын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журмыг хавсралт ёсоор баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн даргад даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХОРООДЫН ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Чингэлтэй дүүргийн хороодын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл /цаашид салбар зөвлөл/ гэх/ нь дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдийн амар тайван амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хороодод ажиллах салбар зөвлөлийн ажлын зохион байгуулалтыг боловсронгуй болгох, эрх үүргийг тодорхойлох, ажлын үр дүнг тооцож цалин урамшуулал олгоход журмын зорилго оршино.

1.2. Салбар зөвлөл нь Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Эрүүгийн хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Ахуйн хог хаягдлын тухай хууль, Хүн худалдаалах гэмт хэргэтэй тэмцэх тухай хууль болон бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан хууль тогтоомжууд болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.3. Салбар зөвлөл нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг 7-9 хүний бүрэлдэхүүнтэйгээр хороодын Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлана.

1.4. Салбар зөвлөлийн орлогч дарга нь хорооны Засаг дарга, нарийн бичгийн дарга нь Олон нийтийн байцаагч байна.

1.5. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг Иргэдийн Нийтийн Хурлын дарга буюу хорооны Зохицуулах салбар зөвлөлийн дарга удирдан зохион байгуулна.

1.6. Салбар зөвлөл нь тэмдэг, хэвлэмэл хуудастай байна.

1.7. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь иргэдийнхээ амар тайван амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хорооныхоо хэмжээнд удирдан зохион байгуулах, хууль тогтоомжийг сурталчлах, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хандсан соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулж явц, үр дүнг тооцоход оршино.

Хоёр. Зохицуулах салбар зөвлөлийн эрх, үүрэг

2.1. Нутгийн захиргааны болон шүүх, прокурор, хууль хяналт, мэргэжлийн байгууллагуудтай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хорооныхоо хэмжээнд удирдан зохион байгуулах;

2.2. Иргэдийнхээ амар тайван амьдрах нөхцөл бололцоог хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сахилга дэг журмыг бэхжүүлэх чиглэлээр иргэд, олон нийтээс гаргасан санал санаачлагыг дэмжиж, хамтран ажиллах;

2.3. Хорооныхоо хэмжээнд гарсан гэмт хэргийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийх, хүрээлэн буй орчны нөлөөллийн дүн шинжилгээ хийж түүнд тохирсон ажлыг шат дараатай зохион байгуулж үр дүнг тооцох;

2.4. Хууль тогтоомжийг сурталчилах, иргэдийн хууль эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;

2.5. Хороодод ажиллаж буй "Хамтарсан баг"-ийн үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэн хамтран ажиллах;

2.6. Үндэсний уламжлалт ёс заншил, хүмүүнлэгийн болон зан заншлыг хэвшүүлэхтэй холбогдсон олон талт ажлыг авч хэрэгжүүлэх;

2.7. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас зохион байгуулж байгаа ажлын явц, үр дүнтэй танилцах заавар, зөвлөгөө өгөх, хамтран ажиллах;

2.8. Хорооныхоо хэмжээнд зохион байгуулж буй ажлын явц, үр дүнгийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулах;

2.9. Хорооныхоо хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үзлэг шалгалт хийж, холбогдох байгууллагад мэдээлэл хүргүүлэх;

2.10. Зайлшгүй шаардлагатай мэдээ, судалгааг гарган холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх ;

2.11. Иргэдийн бүлэг, үүсгэл санаачлагыг дэмжих, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, дээд шатны байгууллагад уламжлах;

2.12. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж урамшуулах, төр засгийн шагналд уламжлах;

Гурав. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт

3.1. Салбар зөвлөл нь хорооныхоо хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий хамтын байгууллага бөгөөд үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

3.2. Салбар зөвлөлийн хуралдааныг дарга болон гишүүдийн олонхийн саналаар зарлан хуралдуулна. Гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хороодын салбар зөвлөлийн хуралдааныг хүчинтэйд тооцно.

3.3. Салбар зөвлөлийн хурлаар хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд гарсан гэмт хэргийн нөхцөл байдал, гэмт хэрэг зөрчлийг бууруулах талаар хийж хэрэгжүүлсэн ажлын явц, үр дүн, иргэдийн бүлэг, үүсгэл санаачлагын хийсэн ажлын явц, үр дүнг хэлэлцэх, төлөвлөсөн ажлуудын хэрэгжилт, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хууль

тогтоомжийг сурталчилсан байдал, соён гэгээрүүлэх ажлын явц үр дүнгийн талаар хэлэлцэнэ.

3.4. Иргэдийнхээ амар тайван амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хорооны хэмжээнд тулгамдсан асуудлыг Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж тогтоол гаргуулж болно.

3.5. Хуралдаанаас тэмдэглэл гарах бөгөөд хуралдааны тэмдэглэлд дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж тэмдэг дарж баталгаажуулна.

3.6. Салбар зөвлөлийн дарга нь зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохицуулах, хуралдаан даргалах, гишүүддээ ажил үүргийг хуваарилан хариуцуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих, ажлынх нь үр дүнг тооцох эрхтэй.

3.7. Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь салбар зөвлөлийн архив бичиг хэргийг хариуцахаас гадна цахим хэлбэрээр ирүүлсэн санал, хүсэлт асуулт хариултын дүнг салбар зөвлөлийн даргад сар бүр мэдээлнэ.

3.8. Салбар зөвлөл нь хийсэн ажлынхаа тайланг сар бүрийн 25-ны дотор дүүргийн ГХУСА33-д ирүүлнэ.

3.9. Салбар зөвлөлийн даргын эзгүйд салбар зөвлөлийн орлогч дарга орон гүйцэтгэнэ.

Дөрөв. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт

4.1. Хороодын салбар зөвлөлийн дарга нарын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын тайлан, төлөвлөгөөний биелэлт, үр дүнг харгалзан хорооны Засаг даргын үндсэн цалингийн 40 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг сар бүр дүүргийн Зохицуулах зөвлөлөөс олгоно.

4.2. Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах бичиг хэрэг, техник тоног төхөөрөмж, бензин шатахуун, олон нийтийн байцаагчийн хувцас форм, иргэдийн бүлэг үүсгэл санаачлагыг дэмжиж хийгдэх төсөл, хөтөлбөрийн зардал, цалин урамшууллыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төсвөөс санхүүжүүлнэ.